



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2022 оны  
04-р сар

Нийгмийн даатгалын санд 2022 оны 04 дүгээр сарын 30-ний байдлаар нийт 5532.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 106.60 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 254017 иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 473.2 тэрбум төгрөг зарцуулжээ.

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын санд энэ оны 04 дүгээр сард 532.4 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 154.9 тэрбум төгрөгөөр өссөн байна

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 83.2% буюу 432.6 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 8.0% буюу 41.9 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 7.% буюу 36.6 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 1.7% буюу 9.0 тэрбум төгрөг;


### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

2022 оны 04 дугаар сард нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 473.2 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 87.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.


### Тэтгэврийн даатгалын сан

Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 444.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 193020 иргэдийн тэтгэвэрт 424.6 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 78,4 хувь буюу 331.6 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 148827 иргэнд зарцуулсан байна.


### Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



### Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөгөөр/



### Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



### Тэтгэмжийн даатгалын сан

Энэ оны 04 дүгээр сард тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 52983 иргэнд 29,1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт тэтгэмжид зарцуулсан хөрөнгийн 20,6 тэрбум төгрөг буюу 70,8 хувийг жирэмсний болон амаржсаны тэтгэмж эзэлж байна.

### Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Тус сангаас 04 дүгээр сард тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон сувиллын зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 2148 иргэнд 4,8 тэрбум төгрөгийг зарцуулав.


### Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын санд 04 дүгээр сард 8,2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 5866 хүний ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид 14,6 тэрбум төгрөгийг зарцуулсан. Сангийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,3 тэрбум төгрөгөөр өсч, зарлага 2,1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

### Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

2022 оны 04 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 276.6 тэрбум төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 98 хувь буюу 271.1 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байна. Мөн авлагын 54.6 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.


### Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/




### ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /сая төг, өссөн дүнгээр/

	2021_04 сар	2022_04 сар	Зөрүү
Тахир дутуугийн	3 729,8	4 187,9	458,1
Тэжээгчээ алдсаны	439,1	489,1	50,0
Тэтгэмж. төлбөрийн	121,8	143,8	22,0
Сувиллын	5,5	57,0	51,5
<b>Нийт дүн</b>	<b>4 296,2</b>	<b>4 877,8</b>	<b>581,6</b>

### Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



### Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага /сая төгрөгөөр/



**Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал**

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 4 дүгээр сарын байдлаар нийт 3 090.71 сая төгрөг төлөвлөснөөс 2 562.08 сая төгрөг зарцуулж, 528.63 сая төгрөг хэмнэсэн байна. Батлагдсан орон тоо 433 байгаагаас 430 орон тоогоор ажилласан.

**Үйл ажиллагааны зардал /сая төгрөгөөр/**

	2021_4 сар	2022_4 сар	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Цалингийн сан. нийгмийн даатгалын шимтгэл	1 866.24	2 015.21	148.97	7.9%
Бараа үйлчилгээний бусад зардал	721,92	546.87	175.05	24.2%
<b>Дүн</b>	<b>2 588,16</b>	<b>2 562.08</b>	<b>26.08</b>	<b>1%</b>